



**БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН
ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1/108

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, 43 дугаар зүйлийн 43.1.6 дахь заалт, Эрчим хүчний салбарын 2023-2024 оны хамт (тариф)-ын хэлэлцээрийн 3.6, 3.8, компанийн 2024-2025 оны хамтын гэрээний 3.4, 3.6 дахь хэсэг, Захирлын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Компанийн ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Шинэчлэн батлагдсан журмыг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг харьяа салбар, хэлтэс, албаны дарга нарт даалгасугай.

3.Компанийн ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, эдийн засгийн хэлтэс (Г.Энхтүвшин)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан гүйцэтгэх захирлын 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/175 дугаартай "Журам батлах тухай" тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ГАНЧУЛУУН

121250914

“БЗӨБЦТС” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын
2025...оны 04 дугаар сарын 04-ны өдрийн
А/108 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГЭЭР НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ЖУРАМ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1.Компанийн технологийн хэвийн найдвартай ажиллагаа, зорилтот түвшний шалгуур үзүүлэлтүүдийг ханган биелүүлж, ажилтнуудыг идэвх санаачилгатай ажиллуулж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх, ажлын үр дүнг үнэлж дүгнэх, нэмэгдэл хөлс олгоход энэхүү журмын зорилго оршино.

1.2.Энэхүү журам нь компани, харьяа салбарын нийт ажилтнуудад сарын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулах ба компани, харьяа салбарын ажилтнуудад сарын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгоход мөрдөж ажиллана.

ХОЁР.НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

2.1.Компани, харьяа салбарын ажилтнуудад тухайн сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохдоо албан тушаалын үндсэн ба тарифт цалингаас тооцож олгоно.

2.2.Компани, харьяа салбарын ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлс нь тухайн ажилтны албан тушаалын сарын үндсэн ба тарифт цалингийн 50.0 (Тавь) хүртэл хувьтай тэнцэх хэмжээтэй байна.

2.3.Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохдоо салбаруудын түгээх үйл ажиллагаанд хамаарах ажилтнуудад энэхүү журмын 2.5.1 дэх шалгуур үзүүлэлтүүдээр, хангах үйл ажиллагаанд хамаарах ажилтнуудад энэхүү журмын 2.5.2 дахь шалгуур үзүүлэлтүүдээр,

2.4.Компанийн түгээх үйл ажиллагаанд хамаарах хэлтэс, алба (түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, шуурхай үйлчилгээ горимын хэлтэс, засвар угсралт реле хамгаалалт автоматикийн алба)-ны ажилтнуудад энэхүү журмын 2.5.3 дахь шалгуур үзүүлэлтүүдээр, хангах үйл ажиллагаанд хамаарах хэлтэс алба (хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, тоолуур хэмжүүрийн алба, дуудлагын төв)-ны ажилтнуудад энэхүү журмын 2.5.4 дэх шалгуур үзүүлэлтүүдээр, компанийн бусад хэлтэс, алба (захиргаа хүний нөөцийн хэлтэс, санхүү бүртгэлийн хэлтэс, хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс, төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, худалдан авах ажиллагаа, хангамжийн алба, тээвэр үйлчилгээний алба, мэдээлэл технологийн

алба)-ны ажилтнуудад энэхүү журмын 2.5.3, 2.5.4, 2.5.5 дахь шалгуур үзүүлэлтүүдээр тус тус тооцож дүгнэнэ.

2.5.Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохдоо дараах шалгуур үзүүлэлтүүдээр дүгнэнэ. Үүнд:

2.5.1. Салбаруудын түгээх үйл ажиллагаанд хамаарах ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн шалгуур үзүүлэлт:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Олговол зохих хувь
1	2	3
1	Технологийн найдвартай ажиллагаа	30.0
2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	5.0
3	Ажлын зохион байгуулалт, чанар үр дүн	7.0
4	Санхүүгийн үйл ажиллагаа	8.0
	Нэмэгдлийн дээд хувь хэмжээ	50.0

2.5.2. Салбаруудын хангах үйл ажиллагаанд хамаарах ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн шалгуур үзүүлэлт:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Олговол зохих хувь
1	2	3
1	Борлуулалтын үйл ажиллагаа	30.0
2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	5.0
3	Ажлын зохион байгуулалт, чанар үр дүн	7.0
4	Санхүүгийн үйл ажиллагаа	8.0
	Нэмэгдлийн дээд хувь хэмжээ	50.0

2.5.3 Компанийн түгээх үйл ажиллагаанд хамаарах хэлтэс, албаны ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн шалгуур үзүүлэлт:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Олговол зохих хувь
1	2	3
1	Түгээх үйл ажиллагаа	30.0
2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	5.0
3	Ажлын зохион байгуулалт, чанар үр дүн	15.0
	Нэмэгдлийн дээд хувь хэмжээ	50.0

2.5.4 Компанийн хангах үйл ажиллагаанд хамаарах хэлтэс, албаны ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн шалгуур үзүүлэлт:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Олговол зохих хувь
1	2	3
1	Хангах үйл ажиллагаа	30.0
2	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	5.0
3	Ажлын зохион байгуулалт, чанар үр дүн	15.0
	Нэмэгдлийн дээд хувь хэмжээ	50.0

2.5.5. Энэхүү журмын 2.5.3, 2.5.4 дэх заалтад хамаарахгүй компанийн хэлтэс, албаны ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн шалгуур үзүүлэлт:

Д/д	Шалгуур үзүүлэлт	Олговол зохих хувь
1	2	3
1	Түгээх, хангах үйл ажиллагаа	30.0
3	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа	5.0
4	Ажлын зохион байгуулалт, чанар үр дүн	10.0
	Нэмэгдлийн дээд хувь хэмжээ	50.0

ГУРАВ.НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХ ҮЗҮҮЛЭЛТИЙГ ДҮГНЭХ

3.1.Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох дээд хувь хэмжээг тогтоохдоо энэхүү журмын хавсралтад заасан шалгуур үзүүлэлтийн биелэлтийг захиргаа хүний нөөцийн хэлтэс, түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс, төлөвлөлт эдийн засгийн хэлтэс холбогдох мэдээ, тайланг үндэслэн харгалзах үзүүлэлтүүдийг хавсралтын дагуу хянаж дүгнэнэ. Үүнд:

3.1.1. Салбаруудын түгээх үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгоход харгалзах үзүүлэлтийн биелэлтийг (журмын 1-р хавсралтаар):

Д/д	Харгалзах үзүүлэлт		Дүгнэх шалгуур үзүүлэлт	Үндэслэл	Дүгнэх нэгж
1	Технологийн зөрчилгүй	1-р зэргийн саатал	Технологийн зөрчилгүй ажилласан байх. Технологийн зөрчил гарсан тохиолдолд харгалзах хувийг тухайн технологийн зөрчлийн тоогоор үржүүлж, олговол зохих хувь хэмжээнээс бууруулж тооцно. Үүнд:	Технологийн зөрчлийн тайлан, мэдээ	ТҮАХБХ
		2-р зэргийн саатал	- Аваар 7.0 хувь 1-р зэргийн сааталд 5.0 хувь 2-р зэргийн сааталд 2.0 хувь Тайлбар: Технологийн зөрчлөөс хасагдах дээд хэмжээ 7.0 хувиас хэтрэхгүй байна.		
	ИСайди биелэлт	Сараар	Цахилгаан хангамжийн найдвартай байдлын индексийн төлөвлөгөөний биелэлт	Тасалдлын индексийн тайлан, мэдээ	ТҮАХБХ
		Өссөн дүнгээр			
	Үзлэгийн графикийн мөрдөлт, чанар, тодорхойгүй тасралтын тоо, шалтгаан		Үзлэгийг графикт хугацаанд нь чанартай гүйцэтгэх, тодорхой бус тасралтыг бууруулсан байх.	Хавсралт маягтын дагуу	ТҮАХБХ
	Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдлын бууралт		Төлөвлөгөөнд тусгагдсан шугам, дэд өртөөний алдагдлыг бууруулсан байх	Хавсралт маягтын дагуу	ТҮАХБХ, ХҮАХБХ, ТЭЗХ
2	Засварын ажлын биелэлт, ажлын чанар, актын иж бүрдэл		Төлөвлөгөөт засварын ажлыг чанартай гүйцэтгэж, гүйцэтгэлийн бичиг баримтыг журмын дагуу бүрдүүлсэн байх	Хавсралт маягтын дагуу	ТҮАХБХ
	ХАБЭА-н зөрчилгүй		Тухайн сард хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) зөрчилгүй ажилласан байх	Хавсралт маягтын дагуу	ХААХ
	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн		Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, ТҮАХБХ-ээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Хавсралт маягтын дагуу	ЗХНХ, ТҮАХБХ
			Хэрэглэгчийн гомдлын шийдвэрлэлт	Хавсралт маягтын дагуу	ТҮАХБХ, Дуудлагын төв
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт, Техникийн программын баяжуулалт, ашиглалтын мэдээ	Хавсралт маягтын дагуу	ТҮАХБХ

4	Үйл ажиллагааны зардлын биелэлт	Үйл ажиллагааны зардлыг сараар болон өссөн дүнгээр батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлээгүй байх (үндсэн хөрөнгийн элэгдэл, ДҮТ болон зохицуулалтын үйлчилгээний хөлс), худалдан авах ажиллагаанаас хамааран тухайн сард төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал (сэлбэг, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл), Хамтын гэрээний 5.5-5.12 дахь заалтын дагуу олгосон зардал, (буцалтгүй тусламж, тэтгэмж), Компанийн удирдлагын шийдвэрээр тухайн сарын төлөвлөгөөнд тусгагдаагүй олгосон зардал (СҮДНХ, ЖҮДНХ, НДШ), үнэ тарифын өөрчлөлт болон гэнэтийн аваар саатал, үйлдвэрлэлийн осолтой холбоотой (шатахуун, томилолт, материал, ашиглалтын зардлууд гм) зардлуудын нөлөөллийг тус тус тооцсон дүнгээр	Зардлын дэлгэрэнгүй тайлан	СБХ, ТЭЗХ
	Үйл ажиллагааны бусад орлогын биелэлт	Батлагдсан зорилтот түвшний төлөвлөгөөний биелэлт (түгээх үйл ажиллагааны төлбөрт үйлчилгээ, хэмжилт, туршилт, реле хамгаалалтын шалгалт, тохируулга, трансформатор засвар, техникийн нөхцлийн орлого, БУЗҮ-ний орлого)	Санхүүгийн программын СТ-2 тайлан	ТҮАБХ, ТЭЗХ

3.1.2. Салбаруудын хангах үйл ажиллагаанд хамаарах ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгоход харгалзах үзүүлэлтийн биелэлтийг (журмын 2-р хавсралтаар):

Д/д	Харгалзах үзүүлэлт	Дүгнэх шалгуур үзүүлэлт	Үндэслэл	Дүгнэх нэгж
1	Борлуулалтын бичилт	Тухайн сард хэрэглэгчдэд борлуулсан ЦЭХ-ийг 100.0 буюу түүнээс дээш хувь хүртэл бичсэн байх. -98.0-99.9 хувь буюу түүнээс дээш хувиар бичсэн байх.	Борлуулалтын мэдээ	ХҮАХБХ, ТЭЗХ
	Тухайн сарын орлого төвлөрүүлэлт (авлага цуглуулалт)	Тухайн сарын ЦЭХ-ний бичилтийг 98.0-аас дээш хувиар төвлөрүүлсэн байх. -95.0-97.9 хувиар төвлөрүүлсэн байх.		
	ЦЭХ-ний үлдэгдэл авлага барагдуулалт	Өмнөх сард үүссэн ЦЭХ-ний авлагыг дараа сарын 20-ны өдрийн дотор бүрэн барагдуулсан байх. (ЦЭХ-ээр хангах гэрээний 6.6 заалтын дагуу дараа сарын 10-ны дотор ЦЭХ-ний төлбөрийг төлдөг хэрэглэгчдийн авлагыг тооцохгүй.)	ЦЭХ-ний үлдэгдэл авлагын мэдээ	

	ЦЭХ-ний алдагдлын төлөвлөгөөний биелэлт /шинийн түгээлт хассан дүнгээр/	Тухайн жилд батлагдсан зорилтот түвшинд тусгагдсан цахилгаан түгээлтийн алдагдлыг бууруулсан байх (шинийн түгээлтийг хассан дүнгээр)	Түгээлтийн алдагдлын мэдээ (Дамжуулах сүлжээнээс шууд авсан хэрэглээг хассан)	
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт	Тухайн сард хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) зөрчилгүй ажилласан байх.	Хавсралт маягтын дагуу	ХААХ
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт ХҮАХБХ-ээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Хавсралт маягтын дагуу	ЗХНХ, ХҮАХБХ
		Хэрэглэгчийн гомдлын шийдвэрлэлт	Хавсралт маягтын дагуу	ХҮАХБХ, Дуудлагын төв
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт	Хавсралт маягтын дагуу	ЗХНХ
4	Үйл ажиллагааны зардлын биелэлт	Үйл ажиллагааны зардлыг сараар болон өссөн дүнгээр батлагдсан төлөвлөгөөнөөс хэтрүүлээгүй байх (үндсэн хөрөнгийн элэгдэл, ДҮТ болон зохицуулалтын үйлчилгээний хөлс), худалдан авах ажиллагаанаас хамааран тухайн сард төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал (сэлбэг, урсгал засвар, хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл), Хамтын гэрээний 5.5-5.12 дахь заалтын дагуу олгосон зардал, (буцалтгүй тусламж, тэтгэмж), тухайн сарын батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал (СҮДНХ, ЖҮДНХ, НДШ), үнэ тарифын өөрчлөлт болон гэнэтийн аваар саатал, үйлдвэрлэлийн осолтой холбоотой (шатахуун, томилолт, материал, ашиглалтын зардлууд г.м) зардлуудын нөлөөллийг тус тус тооцсон дүнгээр.	Зардлын дэлгэрэнгүй тайлан	СБХ, ТЭЗХ
	Борлуулалтын бусад орлогын биелэлт	Тухайн сард батлагдсан ЦЭХ-ний алданги, хангах үйл ажиллагааны төлбөрт үйлчилгээ, тоолуур баталгаажуулалт, маягтын орлогын төлөвлөгөөний биелэлт	Санхүүгийн программын СТ-2 тайлан	ТЭЗХ

3.1.3 Компанийн түгээх үйл ажиллагаанд хамаарах хэлтэс, албаны ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгоход харгалзах үзүүлэлтийн биелэлтийг (журмын 3-р хавсралтаар):

Д/д	Харгалзах үзүүлэлт	Дүгнэх шалгуур үзүүлэлт	Үндэслэл	Дүгнэх нэгж
1	Түгээх үйл ажиллагаа	Салбаруудын түгээх үйл ажиллагааны найдвартай ажиллагаанд ногдох үзүүлэлтийн дундаж хувь хэмжээгээр тооцно.	Энэхүү журмын 3.1.1 дэх хэсэг	ТЭЗХ
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт	Тухайн сард хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) зөрчилгүй ажилласан	Хавсралт маягтын дагуу	ХААХ
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Хавсралт маягтын дагуу	ЗХНХ
		Ажлын цаг ашиглалт, ирц	Ажлын цаг ашиглалтын хувь: 95-100% , Ажлын цаг ашиглалтын хувь: 90-94.9%	
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт.	Хавсралт маягтын дагуу	

3.1.4 Компанийн хангах үйл ажиллагаанд хамаарах хэлтэс, албаны ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгоход харгалзах үзүүлэлтийн биелэлтийг (журмын 4-р хавсралтаар):

Д/д	Харгалзах үзүүлэлт	Дүгнэх шалгуур үзүүлэлт	Үндэслэл	Дүгнэх нэгж
1	Хангах үйл ажиллагаа	Салбаруудын борлуулалтын үйл ажиллагаанд ногдох үзүүлэлтийн дундаж хувь хэмжээгээр тооцно.	Энэхүү журмын 3.1.2 дахь хэсэг	ТЭЗХ
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт	Тухайн сард хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) зөрчилгүй ажилласан	Хавсралт маягтын дагуу	ХААХ
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт	Хавсралт маягтын дагуу	ЗХНХ
		Ажлын цаг ашиглалт, ирц	Ажлын цаг ашиглалтын хувь: 95-100% , Ажлын цаг ашиглалтын	
			Цагийн баланс	

		хувь: 90-94.9%		
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт.	Хавсралт маягтын дагуу	ЗХНХ

3.1.5 Энэхүү журмын 3.1.3, 3.1.4 дэх заалтад хамаарахгүй компанийн хэлтэс, албаны ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгоход харгалзах үзүүлэлтийн биелэлтийг (журмын 5-р хавсралтаар):

Д/д	Харгалзах үзүүлэлт	Дүгнэх шалгуур үзүүлэлт		Үндэслэл	Дүгнэх нэгж
1	Түгээх үйл ажиллагаа, хангах үйл ажиллагаа	Түгээх болон борлуулалтын үйл ажиллагаа тус бүрт ногдох үзүүлэлтийн дундаж хувь хэмжээгээр тооцно.		Энэхүү журмын 3.1.1, 3.1.2 дахь хэсэг	ТЭЗХ
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт	Тухайн сард хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн (ХАБЭА) зөрчилгүй ажилласан		Хавсралт маягтын дагуу	ХААХ
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт		Хавсралт маягтын дагуу	ЗХНХ
		Ажлын цаг ашиглалт, ирц	Ажлын цаг ашиглалтын хувь: 95-100% ,	Цагийн баланс	
			Ажлын цаг ашиглалтын хувь: 90-94.9%		
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт.		Хавсралт маягтын дагуу	

3.2.Харьяа салбарын ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох дээд хувь хэмжээг дараах байдлаар тооцож олгоно. Үүнд:

3.2.1. Түгээх үйл ажиллагаанд хамаарах ерөнхий инженер, засвар, шуурхай үйлчилгээ (Бэрх, Баян-Адарга, Бор-Өндөр, Замын-Үүд, Зүүнбаян, Шивээ-Говь)-ний ажилтнуудад энэхүү журмын 2.5.1-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тооцсон тухайн салбарын хувиар;

3.2.2. Хангах үйл ажиллагаанд хамаарах менежер, хэсэг (Бэрх, Баян-Адарга, Бор-Өндөр, Замын-Үүд, Зүүнбаян, Шивээ-Говь)-ийн ажилтнуудад энэхүү

журмын 2.5.2-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тооцсон тухайн салбарын хувиар;

3.2.3. Салбарын дарга, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хэсэг, эдийн засагч, Захиргааны хэсэг, Санхүү бүртгэлийн хэсэг, Тээвэр үйлчилгээний хэсэг, сумдын борлуулалт хариуцсан шуурхай үйлчилгээ засварын техникч, шуурхай үйлчилгээ засварын монтёруудад энэхүү журмын 2.5.1, 2.5.2-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу тооцсон тухайн салбарын дундаж хувиар;

3.3.Компанийн хэлтэс, албаны ажилтнуудад сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох дээд хувь хэмжээг дараах байдлаар тооцож олгоно. Үүнд:

3.3.1. Ерөнхий инженер 2.5.1, 2.5.3-т заасан шалгуур үзүүлэлтүүдийн дундаж хувиар, Түгээх үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, Шуурхай үйлчилгээ горимын хэлтэс, Засвар угсралт реле хамгаалалт, автоматикийн албаны ажилтнуудад энэхүү журмын 2.5.3-т заасан шалгуур үзүүлэлтүүдийн хувиар;

3.3.2.Бүтээмж хариуцсан менежер 2.5.2, 2.5.4-т заасан шалгуур үзүүлэлтүүдийн дундаж хувиар, Хангах үйл ажиллагаа хариуцсан бодлогын хэлтэс, Тоолуур хэмжүүрийн алба, Дуудлагын төвийн ажилтнуудад энэхүү журмын 2.5.4 -т заасан шалгуур үзүүлэлтүүдийн хувиар;

3.3.3. Хяналт хариуцсан менежер, Төлөвлөлт, маркетинг хариуцсан менежерүүд өөрийн шууд удирдлаганд хамаарах хэлтэс, албаны 2.5.5-д заасан шалгуур үзүүлэлтүүдийн дундаж хувиар, Захиргаа хүний нөөцийн хэлтэс, Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс, Хяналт аюулгүй ажиллагааны хэлтэс, Санхүү бүртгэлийн хэлтэс, Худалдан авах ажиллагаа, хангамжийн алба, Тээвэр үйлчилгээний алба, Мэдээлэл технологийн албаны ажилтнуудад энэхүү журмын 2.5.5-д заасан шалгуур үзүүлэлтүүдийн хувиар;

3.3.4. Салбар, хэлтэс, албаны үйл ажиллагаанаас хамаараагүй хүчин зүйлийн нөлөөллийг холбогдох баримт бичгийг үндэслэн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

3.4.Ажилтанд сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохдоо дараах байдлаар тооцож олгоно. (журмын 6-р хавсралтаар) Үүнд:

3.4.1. Салбарын ажилтан тус бүрт сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохдоо энэхүү журмын 3.2 дахь заалтын дагуу тооцсон хувь хэмжээгээр зургаадугаар хавсралтад заасан үзүүлэлтүүдийн дагуу салбарын дарга, хэсгийн удирдлага 100 (Нэг зуу) хувиар дүгнэнэ.

3.4.2. Компанийн ажилтан тус бүрт сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгохдоо энэхүү журмын 3.3 дахь заалтын дагуу тооцсон хувь хэмжээгээр зургаадугаар хавсралтад заасан үзүүлэлтүүдийн дагуу хэлтэс, албаны дарга 100 (Нэг зуу) хувиар дүгнэнэ.

3.5.Компани, харьяа салбарын ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг энэхүү журмын зургаадугаар хавсралтад заасан үзүүлэлтүүдээр дараах албан тушаалтнууд дүгнэж баталгаажуулна. Үүнд:

3.5.1. Гүйцэтгэх захирал нь ерөнхий инженер, хяналт хариуцсан менежер, бүтээмж хариуцсан менежер, төлөвлөлт хариуцсан менежер, салбарын дарга, өөрийн шууд удирдлагад харьяалагдах хэлтэс, албаны даргын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг;

3.5.2. Ерөнхий инженер, хяналт хариуцсан менежер, бүтээмж хариуцсан менежер, төлөвлөлт хариуцсан менежер нь өөрийн шууд удирдлагад харьяалагдах хэлтэс, албаны даргын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг;

3.5.3. Хэлтэс, албаны дарга нь тухайн нэгжийн ажилтан тус бүрийн сарын ажлыг дүгнэж, сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг;

3.5.4. Салбарын дарга тухайн салбарын ажилтнуудын сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох хувь хэмжээг;

3.6.Харьяа салбар, хэлтэс, алба нь сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтүүдийн биелэлтийг дараа сарын 18-ны өдрийн дотор холбогдох хэлтсүүдэд гаргаж хүргүүлнэ. Хэлтсүүд нь дараа сарын 20-ны өдрийн дотор Төлөвлөлт эдийн засгийн хэлтэст ирүүлнэ. (Амралт, баяр ёслолын өдөр таарвал өмнөх ажлын өдрөөр тооцно.) Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үзүүлэлтүүдийн биелэлтийг заасан хугацаанд ирүүлээгүй бол удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн харгалзах оноог хасч тооцно.

3.7.Төлөвлөлт эдийн засгийн хэлтэс нь холбогдох хэлтсүүдээс ирүүлсэн сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн үзүүлэлтийн биелэлтийг нэгтгэн, саналыг тухайн сарын 24-ний өдрийн дотор Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

3.8.Ажилтан тус бүрт олгох сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсний хувь хэмжээг компанийн хэлтэс, албаны дарга нар компанийн цалин хөлс хариуцсан нягтлан бодогчид, харьяа салбаруудын хэсгийн дарга нар салбарын тооцооны нягтлан бодогчид тухайн сарын 24-ний өдрийн дотор тус тус ирүүлнэ.

ДӨРӨВ. НЭМЭГДЭЛ ХӨЛСИЙГ ДЭЭД ХУВЬ ХЭМЖЭЭГЭЭР ОЛГОХ НӨХЦӨЛ

4.1. Доорх нөхцөлд ажилтанд сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох үндсэн үзүүлэлтүүдийн биелэлтээс хамаарахгүйгээр дээд хувь хэмжээгээр олгож болно. Үүнд:

4.1.1. Эрчим хүчний салбар, аймаг, дүүргээс зохион байгуулсан олон нийтийн ажил (урлаг, спорт, мэргэжлийн болон бусад уралдаан тэмцээн)-д компанийг төлөөлөн идэвхи санаачилгатай оролцож, шагналт байр эзэлсэн;

4.1.2. Компанийн хэмжээнд зохион байгуулагдсан ажил мэргэжлийн уралдаан, сар болон жилийн аян, спортын их наадам, урлагийн их наадамд тэргүүн байр эзэлсэн;

4.1.3. Компани, салбарын хэмжээнд шинэ бүтээл оновчтой санал, техникийн шийдэл, инноваци гаргасан;

4.1.4. Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, тэдгээрийн хор уршигийг нэн даруй арилгах ажлыг гүйцэтгэсэн;

4.1.5. Урьдчилан мэдэх боломжгүй, компанийн хэвийн үйл ажиллагаанд учирч болзошгүй хохирлыг арилгах хойшлуулшгүй ажил гүйцэтгэсэн;

4.1.6. Компанийн хэмжээнд нэг сараас дээш хугацаанд тасралтгүй үргэлжлэх, томоохон цар хүрээтэй эрчим хүчний барилга угсралтын ажилд оролцсон;

4.3. Энэхүү журмын 4.1 дэх хэсгийн дагуу сарын үйл ажиллагааны нэмэгдэл хөлсийг дээд хэмжээгээр олгох саналыг Захиргаа хүний нөөцийн хэлтэст ирүүлсэн тохиолдолд Захирлын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлнэ.

ТАВ. НЭМЭГДЭЛ ХӨЛС ОЛГОХГҮЙ БАЙХ НӨХЦӨЛ

5.1. Доорхи нөхцөлд ажилтанд сарын үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс бодож олгохгүй. Үүнд:

5.1.1. Тухайн сард ноцтой аваар, үйлдвэрлэлийн осол, осолд дөхсөн зөрчил гаргасан (холбогдох салбар, хэлтэс, алба, албан тушаалтан);

5.1.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 60 дугаар зүйлд зааснаар ажилтны ажлын байрыг хэвээр хадгалагдаж байгаа;

5.2. Энэхүү журмын 5.1.1-д заасан нөхцлөөр нэмэгдэл хөлс олгохгүй тухай асуудлыг Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.



**“Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл
хөлс олгох журам”-ын нэгдүгээр хавсралт**

2725910002 2008904

Д/д	Үндсэн үзүүлэлт		Харгалзах үзүүлэлт	Олгох санал (хувь)	Шийдвэр (хувь)	
1	2		3	4	5	
1	Цахилгаан хангамжийн найдвартай байдал (7.0%)		Технологийн зөрчилгүй	1-р зэргийн саатал	5.0%	
				2-р зэргийн саатал	2.0%	
	Нэг хэрэглэгчид ногдох тасалдлын дундаж хугацаа (8.0%)		ИСайди биелэлт	сараар	5.0%	
				Өссөн дүнгээр	3.0%	
	Ашиглалтын түвшин (5.0%)		Үзлэгийн графикайн мөрдөлт, чанар, тодорхойгүй тасралтын тоо, шалтгаан		5.0%	
	Цахилгаан эрчим хүчний түгээлтийн алдагдлын бууралт (5.0%)			5.0%		
Төлөвлөгөөт засвар угсралтын ажлын биелэлт (5.0%)		Засварын ажлын биелэлт, ажлын чанар, актын иж бүрдэл		5.0%		
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт (5.0%)		ХАБЭА-н зөрчилгүй	5.0%		
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн (7.0%)		Удирдлагын үүрэг даалгаврын биелэлт	2.0%		
			Хэрэглэгчийн гомдлын шийдвэрлэлт	2.0%		
			Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт (Техникийн программын баяжуулалт, ашиглалт)	3.0%		
4	Санхүүгийн үйл ажиллагаа (8.0%)	Үйл ажиллагааны зардлын биелэлт (5.0%)	Сараар	3.0%		
			Өссөн дүнгээр	2.0%		
		Үйл ажиллагааны бусад орлогын биелэлт			3.0%	
	Нийт хувь			50.0%		



“Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”-ын хоёрдугаар хавсралт

2725010002 ш. 2008904

Д/д	Үндсэн үзүүлэлт	Харгалзах үзүүлэлт		Олгох санал (хувь)	Шийд-вэр (хувь)
1	2	3		4	5
1	Борлуулалтын бичилт (10%)	100 % буюу түүнээс дээш бол		10.0%	
		98.0-99.9% бол		5.0%	
	Тухайн сарын орлого төвлөрүүлэлт (авлага цуглуулалт) (10%)	98.0-аас дээш хувь		10.0%	
		95.0-97.9 хувь		5.0%	
	ЦЭХ-ний үлдэгдэл авлага барагдуулалт (5%)	20 хүртэл хоногийн насжилттай		5.0%	
	ЦЭХ-ний алдагдлын төлөвлөгөөний биелэлт /шинийн түгээлт хассан дүнгээр/ (5%)		5.0%		
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт (5.0%)	ХАБЭА-н зөрчилгүй		5.0%	
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн (7.0%)	Удирдлагын үүрэг даалгаврын биелэлт		2.0%	
		Хэрэглэгчийн гомдлын тоо, шийдвэрлэлт		2.0%	
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт		3.0%	
4	Санхүүгийн үйл ажиллагаа (8.0%)	Үйл ажиллагааны зардлын биелэлт (5.0%)	Сараар	3.0%	
			Өссөн дүнгээр	2.0%	
		Борлуулалтын бусад орлогын биелэлт		3.0%	
Нийт хувь				50.0%	

“Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл
хөлс олгох журам”-ын гуравдугаар хавсралт

Д/д	Үндсэн үзүүлэлт	Харгалзах үзүүлэлт	Олгох санал (хувь)	Шийд-вэр (хувь)
1	2	3	4	5
1	Түгээх үйл ажиллагаа (30.0%)	Найдвартай ажиллагаанд ногдох дээд хэмжээ	30.0%	
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт (5.0%)	ХАБЭА-н зөрчилгүй	5.0%	
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн (15.0%)	Удирдлагын үүрэг даалгаврын биелэлт	5.0%	
		Ажлын цаг, ашиглалт	5.0%	
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт	5.0%	
Нийт хувь			50.0%	

“Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл
хөлс олгох журам”-ын дөрөвдүгээр хавсралт




Д/д	Үндсэн үзүүлэлт	Харгалзах үзүүлэлт	Олгох санал (хувь)	Шийд-вэр (хувь)
1	2	3	4	5
1	Хангах үйл ажиллагаа (30.0%)	Борлуулалтын үйл ажиллагаанд ногдох дээд хэмжээ	30.0%	
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт (5.0%)	ХАБЭА-н зөрчилгүй	5.0%	
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн (15.0%)	Удирдлагын үүрэг даалгаврын биелэлт	5.0%	
		Ажлын цаг ашиглалт	5.0%	
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт.	5.0%	
Нийт хувь			50.0%	



“Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл хөлс олгох журам”-ын тавдугаар хавсралт

Д/д	Үндсэн үзүүлэлт	Харгалзах үзүүлэлт	Олгох санал (хувь)	Шийд-вэр (хувь)
1	2	3	4	5
1	Түгээх үйл ажиллагаа, хангах үйл ажиллагаа (30.0%)	Найдвартай ажиллагаанд ногдох дээд хэмжээ	15.0%	
		Борлуулалтын ажиллагаанд ногдох дээд хэмжээ	15.0%	
2	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн хууль, дүрэм журмын мөрдөлт (5.0%)	ХАБЭА-н зөрчилгүй	5.0%	
3	Ажлын зохион байгуулалт чанар, үр дүн (15.0%)	Удирдлагын үүрэг даалгаврын биелэлт	5.0%	
		Ажлын цаг ашиглалт	5.0%	
		Сарын төлөвлөгөөт ажил, графикт мэдээ, тайлангийн биелэлт	5.0%	
Нийт хувь			50.0%	



“Сарын үйл ажиллагааны үр дүнгээр нэмэгдэл
хөлс олгох журам”-ын зургаадугаар хавсралт

Батлагдсан хувь хэмжээ:

Д/д	Овог нэр	Албан тушаал	Шалгуур үзүүлэлтүүд				Тайлбар
			Сарын төлөвлөгөөт ажлын биелэлт (50.0 хувь)	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт (30.0 хувь)	Ажлын цаг ашиглалт 20.0 хувь)	Олговол зохих хувь (50.0%)	
1	2	3	4	5	6	7	8